



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайншанд сумын ЕБ-ын 3-р сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/63/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд 2022 он	Тэргүүлэх аудитор:	Т.Ган-Өлзий
	Утас: 70522734	Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Багийн ахлагч аудитор:	Ш.Сувдаа
		Цахим хаяг: smaudit97@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022.02.25 № 1-6/260

танай _____-ны № _____-т

САЙНШАНД СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 3 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Н.ОЮУНБУД ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

This PC: D/2022 onii ajil/A4 toot

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	223.2	248.7
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,289.2	4,144.5
	Нийт хөрөнгийн дүн	4,512.5	4,393.3
	Нийт өр төлбөрийн дүн		0.01
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,512.5	4,393.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,512.4	4,393.3
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,385.5	1,431.6
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,482.5	1,550.9
	Үйл ажиллагааны үр дүн	(97.0)	(119.3)
	Үйл ажиллагааны бус үр дүн	(6.3)	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(103.4)	(119.3)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,272.9	1,272.9
	Тайлант оны үр дүн	2,823.5	2,600.0
	Эцсийн үлдэгдэл	4,615.9	4,393.1
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,313.6	1,403.4
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,291.9	1,380.2
	Үйл ажиллагааны ЦМГ	21.7	23.1
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(21.7)	(23.1)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,405.3	1,387.9
	Урсгал зардал	1,405.3	1,387.9
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,405.3	1,387.9
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	275.7	258.4
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	1,129.5	1,129.5

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сайншанд сумын 3 дугаар сургууль нь хүүхдийн хөгжлийг дэмжих суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах зорилго тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлээс сангийн сайдын 2021 оны 190 дугаар тогтоол, ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол, санхүү нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тушаал, тогтоолуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитын excel файлын данс шинэчлэгдээгүйгээс ctsystem.mn программаас хөрвүүлсэн санхүүгийн тайлан дахь дансдын үлдэгдлүүд буруу илэрхийлэгдэж байна. Тухайлбал: Зөрүүтэй татагдаж байгаа дансдууд

Орлого үр дүнгийн тайлан: Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого/Үндсэн хөрөнгө-120017

Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого/Бараа материал-120018

Мөнгөн гүйлгээний тайлан: Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг-213305

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар дэлгэрэнгүй бүртгэл болон бусад баримт мэдээллийг шалгахад тус байгууллага нь тайлант онд нийт 149 төрлийн мэдээлэл байршуулах бөгөөд 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,392.8 сая төгрөгийн 46 орлогын гүйлгээ, 269.1 сая төгрөгийн 14 зарлагын гүйлгээ, өмч хөрөнгө, төсөв зарцуулах 55 тушаал, шийдвэрийг байршуулахаар байна.

Дээрх мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэлтэй тулгаж, шалгахад 5.0 сая төгрөгөөс дээш орлого бүхий гүйлгээнээс 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

5.0 сая төгрөгөөс дээш зарлага бүхий гүйлгээг бүрэн, өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой нийт 55 тушаал шийдвэрийг байршуулахаас 55 тушаал шийдвэрийг хугацаанд нь бүрэн мэдээлж байршуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлан, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааны мэдээллийг шилэн дансны цахим системд хуулиар тогтоосон хугацаанд, бүрэн байршуулсан байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ковид-19 цар тахалтай холбоотой дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүй хандив, тусламж хүлээн авч, зарцуулсан байх асуудлыг авч үзэх хэрэгтэй.

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 204.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

Машин тоног төхөөрөмж, зам гүүрийн байгууламж болон бусад үндсэн хөрөнгө дансны хуримлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл нь тодруулга тайлангаас 204.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байсныг аудитын явцад залруулав.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс таггалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	1	204.8	1	204.8	-	-				
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	1	204.8	1	204.8	-	-				